



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2018.03-14 № 16

БНЭУ-ын Засгийн газраас олгож буй  
1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй  
зээлийн хүрээнд хэрэгжих "Газрын тос  
боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн  
талаар асуулга тавих тухай

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар соёрхон баталсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импортын банк хооронд байгуулсан Зээлийн ерөнхий хэлэлцээрээр БНЭУ-ын Засгийн газраас олгох 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийг "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-д зарцуулахаар шийдвэр гарсан.

Энэхүү зээлийн зориулалт оновчтой эсэх талаар болон зээлээр хэрэгжүүлэх төслийн техник эдийн засгийн тооцоолол, үндэслэл, үр ашгийн тооцоо, төсөл боловсруулах явц, төсөл хэрэгжүүлэх субъект, зээлийн эргэн төлөлт, монголын ард түмэнд хүртэх өгөөж гэх мэт олон асуудлуудад миний бие эхнээс нь нухацтай хандаж, УИХ-ын чуулганы хуралдаан дээр хэд хэдэн удаа байр сууриа илэрхийлж байсан билээ.

2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан дээр дурьдсан асуудлаар УИХ-ын гишүүн миний тавьсан асуултанд тухай үеийн Засгийн газар, асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний хариулсан байр суурь өнөөгийн Засгийн газраас мэдээлж байгаа мэдээлэл, УИХ-ын гишүүний асуултанд хариулж байгаа байдалтай зөрчилдөж байгаа тал ажиглагдаж байгаа тул УИХ-ын гишүүний хувьд энэхүү эргэлзээг тайлах, дээрх асуудалд өөрийн итгэл үнэмшлээр хандах, иргэд, олон нийтэд үнэн зөв, бодит мэдээлэл хүргэх үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7.1.13-ыг үндэслэн Танд дараахь асуулгыг тавьж байна.

1. Монгол Улсын газрын тосны батлагдсан нөөцийн хэмжээ 2018 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар ямар хэмжээнд байгаа, газрын тос боловсруулах үйлдвэрийн үр ашгийн тооцоолол хийгдсэн эсэх талаар;(Аль улсад үйлдвэрлэсэн техник, технологи, жилд хэдэн тонн нефть бүтээгдэхүүн боловсруулах, хэдэн жилийн хугацаанд хөрөнгө оруулалтаа нөхөх, мэргэжилтэй ажилтан, боловсон хүчний нөөц, бэлтгэл ямар байгаа талаар)

2. БНЭУ-аас авч байгаа 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн гэрээ хэзээнээс үйлчилж эхэлсэн, мөн гэрээ үйлчилж эхэлснээр зээлийн хүү бодогдож эхэлсэн эсэх, зээлийн хүүгийн хэмжээ, эргэн төлөлтийн тооцоолол ямар байгаа талаар;

3. Дээрх зээлээр хэрэгжүүлэх "Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл"-ийн ТЭЗҮ боловсруулах ажлын явц ямар хэмжээнд хүрсэн талаар;

4. 2017 онд ЗГ-аас дээрх төслийн ТЭЗҮ-г боловсруулж байх явцад олон нийтэд мэдээлж байсанчлан төслийн санхүүжилт 1 тэрбум ам.долларт багтаж байгаа эсэх талаар;

5. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт байгуулах нь Дархан, Чойр, Зүүнбаян, Бор-Өндөр зэрэг өмнө нь тодорхой түвшинд яригдаж, судлагдаж байсан төвлөрсөн хот суурин газруудыг түшиглэж байгуулахаас давуу болох үндсэн шалтгааны талаар;

6. 645 км хоолойг ямар гүнд, хос буюу дан ямар хэлбэрээр, ямар өртөгтэй, аль улсын технологиор татахаар зураг, төсөв, тооцоолол, хийгдэж байгаа талаар болон уг хоолойн ашиглалт, хамгаалалт, урсцыг сайжруулах бодисын хангамж, улирлын чанартай арчилгаа болон хоолойгоор татах бүтээгдэхүүний нэмэгдэх өртгийн тооцооллын талаар;

7. Байгаль орчны мэргэжлийн байгууллагууд, судлаач эрдэмтдээр Монгол орны зүүн урд бүсэд 645 км урттай газрын тосны шугам хоолойг байгуулах нь тус бүс нутгийн байгаль-экологийн тэнцвэрт байдалд хэрхэн нөлөөлөх талаар судалгаа хийлгэж, дүгнэлт, зөвлөмж гаргуулсан эсэх талаар;

8. Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тооцоогоор үйлдвэрлэлд хоногт хичнээн тонн ус шаардагдах, усны нөөцийн судалгааг хийж байгаа эсэх, хэрэв хийж байгаа бол судалгааны үр дүн ямар байгаа талаар;

9. Газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах ажил хэзээнээс эхэлж, нийт хэдэн жил барихаар тооцоолж байгаа талаар;

10. Тамсагийн сав газраас олборлож байгаа нефть бүтээгдэхүүн дээр түшиглэн үйл ажиллагаа явуулахад хөрш орнуудаас өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалан үзүүлэх нөлөөллийг тооцоолж байгаа эсэх талаар; (ҮАБ-ын хувьд болон Монгол Улсаас БНХАУ 1 жилд авч байгаа 1 тэрбум орчим ам.долларын түүхий нефтийн импорт, ОХУ-ын хувьд манай улсад нийлүүлдэг 1 тэрбум орчим ам.долларын нефть бүтээгдэхүүний экспортын эрх ашиг хөндөгдөх талаас)

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33-р зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд сонсгохыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УИХ-ЫН ГИШҮҮН



Ё.БААТАРБИЛЭГ